



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/119/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас:88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлт, тоног төхөөрөмж худалдаж авсан 9,9 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байсан зөрчлийг аудитын хугацаанд байршуулж ажилласан.	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
Менежментийн захидал	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН Т
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
З.ЦЭРЭНДОРЖ ТАНАА Г

2020.02.10 № 1/68

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020028

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

~~ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.МӨНХБАТ~~

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Няглан бодох бүртгэлийн болон Улсын секторын няглан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

2.1. Оршил

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга З.Цэрэндорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.05-аас 2020.02.07-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.08-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын ЗДТГ нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.25-ний өдрийн 147 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэж, сумын эдийн засгийн өсөлтийг тогтвортой хөгжүүлэн, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулахад оршино"

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сахилга хариуцлага, ёс зүйг эрхэмлэн дээдэлж, ур чадвартай, зөв манлайлалтай байж ил тод, түргэн шуурхай, эелдэг харилцаатай соёлтой үйлчилгээг ард иргэдэд үзүүлнэ

1. Хорт зуршилгүй, гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болно.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөнө.

3. Мэдлэг ур чадвараа хөгжүүлэн, зөв манлайлалтай байна.

4. Мэдээллийн ил тод нээлттэй түргэн шуурхай үйлчилгээг хэвшүүлнэ
Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Жинст сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Жинст сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 35 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 351422,0 мянган төгрөгөөс тооцон 7028,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2% буюу 7028,4 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104377,4 мянган төгрөгөөр буюу 11,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	3400,0	3400,0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	7637,9	15136,5	7498,6
Үндсэн хөрөнгө	1202833,4	1307210,8	104377,4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-340257,1	-354406,3	14149,1
Нийт хөрөнгө	873614,2	971341,1	97726,9
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	873614,2	971341,1	97726,9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	873614,2	971341,1	97726,9

Авлага дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй нь ЗДТГ-ын өргөтгөл хийгдээгүйгээс зураг төсвийн үнийг суутгах боломжгүй байгаагаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн “ЦЭСДА” ХХК –аар сумын ЗДТГ-ын газрын өргөтгөлийн зураг төсөв хийлгэсэн бөгөөд тухай ажил хийгдээгүй байгаа учраас авлага барагдаагүй байна. Энэ нь найдваргүй авлага үүсэх үр дагавартай.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь ОНХС-гийн хөрөнгөөр худалдаж авсан 9300,0 мянган төгрөгийн өвсийг хөрөнгийн орлогод бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2013-2019 онд худалдаж авсан 5836,5 мянган төгрөгийн бараа материал байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь ОНХС-гаас 28512,5 мянган төгрөгийн гүний худаг 2, цагдаагийн албанд 3,0 сая төгрөгөөр посийн машин, ХХААЯ-ны хөрөнгө оруулалтаар 133291,8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжиж ирснээс

шалтгаалжээ. Төсвийн хөрөнгөөр 5206,4 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авч хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данснаас цаашид албан хэрэгцээнд ашиглах боломжгүй болсон 65633,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дугаар сарын 31 ний өдрийн 10 дугаар тогтоол 49622,3 авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 25 ний өдрийн 129 дүгээр тогтоол 2402,0 халуун усны барилга, сумын ИТХ-ын 2019 оны 05 дугаар сарын 15 ний өдрийн 12 дугаар тогтоолоор 13609,0 тавилга эд хогшил, акталж данснаас хассан.

Биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй биет бус хөрөнгийн хасагдуулга данс 483,3 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 339335,2 мянган төгрөгийн хоорондын тооцоо үүсэж ажилласан бөгөөд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 971341,1 мянган төгрөг болж 97726,9 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардлаар өссөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 18284,6 мянган төгрөгийн бичилт нь дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталж данснаас хассаны улмаас үүссэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралттай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Жинст сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 600,0 мянган төгрөгийн орлого оруулахаар төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 700,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116,6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсөвт байгууллагын өөрийн орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Хаан банкны халаалтын төлбөрийн орлого	600,0	700,0	100,0	116,6
Нийт дүн	600,0	700,0	100,0	116,6

Тайлант онд 100,0 мянган төгрөгийн орлого давсан халаалтын зардлын тооцоог 7 сараар тооцож гэрээ байгуулж ажилласантай холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 зориулалтад 292963,2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 292963,2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 292963,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 292363,2 мянга, 600,0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 292817,8 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь өөрийн орлогоос давж биелсэн 100,0 мянган төгрөгийг төлөвлөгөөгүй зарцуулсан,

цалингийн зардлаас 238,2 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 4,0 мянга буюу нийт 245,3 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсөв захирагч буюу аймгийн ангилагдаагүй зардлаас 7500,0 мянга, аймгийн ГБХЗХТ-өөс 1000,0 мянга нийт 8500,0 мянган төгрөг нэмэлтээр санхүүжүүлсэн бөгөөд 7500,0 мянган төгрөгийг зардлыг тэмээчдийн зөвлөгөөнд, 1000,0 мянган төгрөг нь хамтарсан багийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 35 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 27 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 20022,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 972,0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 750,0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 18300,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 18300,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад Зочид төлөөлөгч хүлээн авах зардал, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулах цаг хугацааны боломжгүйгээс үзээгүй болно.

Аудитаар дараах 20022,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 972,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 750,0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Засаг даргын нөөц хөрөнгө

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам болон нутаг дэвсгэртээ боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиглэлээр тайлант онд 3150.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 600,0 мянган төгрөгөөр нутгийн зөвлөлийн уулзалтын шагналын зарцуулсан, 250,0 мянган төгрөгийг сумдын ЗДТГ-ын албан хаагчдын бүсийн тэмцээний бооцооны төлбөрт тус тус шилжүүлж журмыг зөрчиж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох.

2.Бараа материал

Холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэр болон өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гараагүй байхад оны эхний үлдэгдэл нэг бүр нь 16,0 мянган

төгрөгийн үнэтэй 102 уут хивгээс 5 уут хивгийг нэг бүрийн 10.0 мянган төгрөгөөр, 92 уут хивгийг 15.0 мянган төгрөгөөр тус тус нийт 122.0 мянган төгрөгөөр үнэ бууруулж зарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.5 5-т “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих гэсэн заалтыг зөрчсөн, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Жинст сумын ЗДТГ-нь 2018 онд Жинст сумын Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардлаас сум хөгжүүлэх сангийн мэдээллийн нэгдсэн программыг 750,0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч программыг хөрөнгийн орлогод аваагүй, бүртгэл тайланд тусгаагүй, ашиглаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 18300,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 5 ний өдрийн 47 тоот тогтоолоор батлагдсан журмын 1 дүгээр хавсралт “Аж ахуй нэг, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага” нийцүүлж нягтлан бодох бүртгэлийн хөтлөх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Жинст сумын ЗДТГ нь Төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тухай жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 3 дугаар сард хугацаа хоцроож мэдээлсэн, Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 3,4,9 дүгээр сард тус тус нийт 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	91	5	
6	Нийт	27	151	145	6	

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгө

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд өөрийн орлогын төлөвлөгөөг 100,0 мянган төгрөгөөр давуулж биелүүлсэн боловч зөвшөөрөлгүй зарцуулсан, зочид төлөөлөгч хүлээж авах зардалд 4000,0 мянган төгрөг батлагдаж тухай зардлыг тэмээчдийн зөвлөгөөн болон шагнал урамшуулал, бусад зардал арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан байна.

3.1.1 Эрсдэл:

Төсвийн зардлыг зориулалт бусаар зарцуулах эрдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын 6 дугаар хавсралтад заасан Зочид төлөөлөгч хүлээн авах /210703/ "гадааны зочид төлөөлөгч,... МУ-ын болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбоотой гарах зочид буудал, хоол,унаа, бэлэг дурсгалын эд зүйлс олгох зарцуулна" гэсэн заалтыг мөрдөж, зориулалтын дагуу зарцуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.2.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын хөрөнгийн дансанд нийт 7 төрлийн, 3800.0 мянган төгрөгийн программ бүртгэлтэй байгаагаас ашиглалтгүй элэгдлийн хугацаа дууссан Төрийн сангийн нэгтгэлийн, архивын, санхүүгийн "Венница" зэрэг 850.0 мянган төгрөгийн программ, 2016 онд худалдаж авсан нэр нь тодорхой биш оноор нь орлого авсан 450.0 мянган төгрөгийн үнэ бүхий программ байгаа бөгөөд хэн ашигладаг нь тодорхой биш ашиглалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон өмчийн тухай хууль 31 дүгээр зүйлийн 1.Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.

3.2.2. Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

3.2.3. Өгсөн зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу ашиглалтгүй байгаа программ хангаж судалж холбогдох журмын дагуу шийдвэрлэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно

3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Илрүүлэлт:

Тус сумын хог тээврийн КАМА маркийн автомашин нь 2012 онд Тогтвортой амьжиргаа төслөөс 12.9 сая төгрөгийн машиныг үнэ төлбөргүй шилжүүлж байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн боловч холбогдох бичиг баримтыг одоог хүртэл аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараах үүрэг хүлээнэ”, 19.3.1 техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах; 19.3.2-т “авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн бичиг баримтын бүрдлийг хангах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.3.1 Эрсдэл:

Автомашиныг данс бүртгэлд тусгаагүй байх

3.3.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшлийн авто тээврийн хэрэгслийн бичиг баримтын байгууллагын нэр дээр шилжүүлж цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.3.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөрчлийг арилгаж ажиллана

3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.4.1 Илрүүлэлт:

Тухайн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлаагүй, байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2.-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: НБББББ-ыг боловсруулж ажиллана

3.5 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.5.1 Илрүүлэлт:

“Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн "Acolous" санхүүгийн программ нь нэмэлтээр “Payoll” программаар цалин хөлсний бүртгэлийг хөтөлдөг бөгөөд тухай байгууллага excel файл ашиглаж байна нь Татвар, нийгмийн даатгал, бусад санхүү, эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй харилцан уялдаатай, мэдээлэл солилцох боломжтой эсэхийг шалгахад цалин хөлсний бүртгэл, албан татвар хурааж, нийгмийн даатгалын шимтгэлийн бүртгэл стандарт шаардлагад нийцэхгүй байна.

Энэ нь (Үнэн зөв байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ний өдрийн 1 дүгээр хавсралт “Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг зөрчсөн байна.

3.4.4 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж мэдээлэл солилцох боломжгүй стандартын шаардлага хангаагүй байх

3.4.5 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ний өдрийн 1 дүгээр хавсралт “Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-д нийцүүлж нягтлан бодох бүртгэлийг программд иж бүрэн хамруулж бүртгэж, тайлагнах.

3.4.6 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Стандарт шаардлагад нийцүүлж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,037,950.00	18,536,550.00
33	АВЛАГА	3,400,000.00	3,400,000.00
335	Бусад авлага	3,400,000.00	3,400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	3,400,000.00	3,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,637,950.00	15,136,550.00
354	Хангамжийн материал	7,637,950.00	15,136,550.00
35420	Аж ахуйн материал	499,000.00	603,800.00

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35470	Бусад хангамжийн материал	7,138,950.00	14,532,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	862,576,264.67	952,804,572.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	862,576,264.67	952,804,572.27
392	Биет хөрөнгө	849,624,473.31	940,336,114.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	653,253,180.70	638,285,941.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,042,516.84	-66,802,333.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,170,760.00	117,244,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,222,266.26	-71,898,076.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,813,346.10	201,042,040.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,328,313.64	-45,927,592.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,023,331.91	49,468,555.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,878,646.53	-30,059,981.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	265,904,384.00	286,381,090.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-131,068,786.13	-137,518,329.48
39217	Ном	00.00	120,000.00
393	Биет бус хөрөнгө	12,951,791.36	12,468,458.04
39301	Програм хангамж	3,800,000.00	3,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,716,666.64	-2,199,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	10,868,458.00	10,868,458.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	873,614,214.67	971,341,122.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	873,614,214.67	971,341,122.27
51	Засгийн газрын хувь оролцоо	873,614,214.67	971,341,122.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	382,993,124.00	382,993,124.00
51101	Өмч: - төрийн	382,993,124.00	382,993,124.00
512	Хуримтлагдсан үр дүн	121,088,068.88	237,099,671.35
51210	Өмнөх үеийн үр дүн	121,088,068.88	139,372,763.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	97,726,907.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	369,533,021.79	351,248,326.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	873,614,214.67	971,341,122.27

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	394,634,992.10	475,667,601.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,520,499.10	174,804,401.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,520,499.10	174,804,401.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,520,499.10	174,804,401.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	700,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,070,499.10	174,104,401.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	335,114,493.00	300,863,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,168,493.00	8,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,168,493.00	7,500,000.00

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	294,946,000.00	292,363,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	294,946,000.00	292,363,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	334,498,918.86	361,711,941.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,498,918.86	361,711,941.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	319,034,769.86	360,466,638.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,286,079.00	195,250,267.00
210101	Үндсэн цалин	171,286,079.00	195,250,267.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,179,719.00	23,574,551.00
210201	Тэтгэврийн даатгал	20,179,719.00	23,574,551.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,512,443.00	17,461,044.00
210301	Гэрэл, цахилгаан	2,447,453.00	2,961,944.00
210302	Түлш, халаалт	16,064,990.00	14,499,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,533,213.00	19,004,100.00
210401	Бичиг хэрэг	3,550,800.00	2,735,520.00
210402	Тээвэр, шатахуун	17,822,393.00	14,709,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	807,920.00	615,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	145,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,352,100.00	799,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,657,500.00	1,679,500.00
210602	Тавилга	00.00	55,000.00
210604	Урсгал засвар	1,657,500.00	1,624,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,499,500.00	11,046,000.00
210702	Дотоод албан томилолт	6,499,500.00	7,046,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,509,240.00	19,272,584.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,509,240.00	15,708,584.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,857,075.86	73,178,592.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,582,500.00	9,524,851.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,000.00	100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,134,575.86	63,553,741.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,464,149.00	1,245,303.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,125,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,125,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,239,149.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,239,149.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	245,303.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	245,303.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	60,136,073.24	113,955,659.72

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,059,141.27	16,228,752.12
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	16,228,752.12
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	51,059,141.27	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-51,059,141.27	-16,228,752.12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>9,076,931.97</u>	<u>97,726,907.60</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>335,564,493.00</u>	<u>301,601,653.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450,000.00	700,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	450,000.00	700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	450,000.00	700,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	335,114,493.00	300,901,653.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,168,493.00	8,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,168,493.00	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	294,946,000.00	292,363,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	294,946,000.00	292,363,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	38,453.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	38,453.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>335,564,493.00</u>	<u>301,601,653.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	335,564,493.00	301,601,653.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,700,344.00	300,317,897.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,654,610.00	194,547,390.00
210101	Үндсэн цалин	150,864,137.00	159,666,107.00
210102	Нэмэгдэл	20,790,473.00	34,881,283.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,811,188.00	24,277,428.00
210201	Тэтгэврийн даатгал	18,003,726.00	16,436,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	451,315.00	1,960,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	362,854.00	1,568,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	91,464.00	391,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	901,829.00	3,920,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,251,193.00	17,461,044.00

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	2,447,453.00	2,961,944.00
210302	Түлш, халаалт	15,803,740.00	14,499,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,655,113.00	19,028,900.00
210401	Бичиг хэрэг	3,442,800.00	2,506,700.00
210402	Тээвэр, шатахуун	17,822,393.00	14,559,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915,920.00	964,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,500.00	299,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,278,500.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,257,500.00	7,000,000.00
210602	Тавилга	1,600,000.00	5,005,500.00
210604	Урсгал засвар	5,657,500.00	1,994,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,499,500.00	11,046,000.00
210702	Дотоод албан томилолт	6,499,500.00	7,046,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,375,740.00	17,282,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,298,740.00	13,645,784.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,000.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,195,500.00	9,674,851.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,095,500.00	9,574,851.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,864,149.00	1,283,756.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,525,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	27,525,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	1,038,453.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	38,453.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,239,149.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,239,149.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	245,303.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	245,303.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,800,666.00	340,970,392.00	147,223,178.73	00.00	866,994,236.73
C07	Тайлант үеийн үр дүн	4,192,458.00	00.00	9,076,931.97	00.00	13,269,389.97
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	369,533,021.79	121,088,068.88	00.00	873,614,214.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	18,284,694.87	00.00	18,284,694.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,993,124.00	369,533,021.79	139,372,763.75	00.00	891,898,909.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-18,284,694.87	00.00	00.00	-18,284,694.87
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	97,726,907.60	00.00	97,726,907.60
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	351,248,326.92	237,099,671.35	00.00	971,341,122.27

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,046,000.00	293,156,851.00	292,963,200.00	292,817,897.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295,046,000.00	293,156,851.00	292,963,200.00	292,817,897.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,719,200.00	265,531,851.00	291,963,200.00	291,817,897.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,730,200.00	171,654,610.00	194,785,600.00	194,547,390.00
210101	Үндсэн цалин	135,455,400.00	135,379,810.00	158,458,300.00	159,666,107.00
210102	Нэмэгдэл	36,274,800.00	36,274,800.00	36,327,300.00	34,881,283.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,855,300.00	19,811,188.00	24,278,200.00	24,277,428.00
210201	Тэтгэврийн даатгал	12,603,800.00	13,208,726.00	16,436,400.00	16,436,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,812,900.00	1,649,515.00	1,960,500.00	1,960,500.00

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,450,300.00	1,593,882.00	1,568,300.00	1,568,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	362,600.00	331,064.00	392,100.00	391,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,625,700.00	3,028,001.00	3,920,900.00	3,920,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,261,900.00	18,251,193.00	17,461,900.00	17,461,044.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,300.00	2,447,453.00	3,045,300.00	2,961,944.00
210302	Түлш, халаалт	15,216,600.00	15,803,740.00	14,416,600.00	14,499,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,487,800.00	27,486,620.00	18,928,900.00	19,028,900.00
210401	Бичиг хэрэг	3,479,400.00	3,478,500.00	2,506,700.00	2,506,700.00
210402	Тээвэр, шатахуун	16,653,900.00	16,653,900.00	14,559,100.00	14,559,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,021,200.00	869,360.00	964,000.00	964,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	17,500.00	299,100.00	299,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,333,300.00	6,467,360.00	600,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,257,500.00	7,257,500.00	7,000,000.00	7,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,500,000.00	00.00	00.00
210602	Тавилга	1,600,000.00	1,600,000.00	5,000,000.00	5,005,500.00
210604	Урсгал засвар	5,657,500.00	4,157,500.00	2,000,000.00	1,994,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,550,800.00	6,499,500.00	11,046,600.00	11,046,000.00
210702	Дотоод албан томилолт	6,550,800.00	6,499,500.00	7,046,600.00	7,046,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	4,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,376,700.00	6,375,740.00	8,786,300.00	8,782,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,304,200.00	6,303,240.00	5,149,800.00	5,145,784.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00	22,500.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	50,000.00	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8199000.00	8195500.00	9675700.00	9674851.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,099,000.00	8,095,500.00	9,575,700.00	9,574,851.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	100,000.00	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1500000.00	100000.00	1000000.00	1000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	100,000.00	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	100,000.00	1,000,000.00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,046,000.00	293,156,851.00	292,963,200.00	292,817,897.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	294,446,000.00	292,706,851.00	292,363,200.00	292,117,897.00
132001	Орон нутгийн төсвөөс	294,446,000.00	292,706,851.00	292,363,200.00	292,117,897.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	450,000.00	600,000.00	700,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	450,000.00	600,000.00	700,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	21	21
620001	Удирдах ажилтан	3	3	3	3

Жинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	13	13
620003	Үйлчлэх ажилтан	5	5	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21	21	21
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	9	9
650009	Төрийн үйлчилгээний	5	5	5	5
650011	Улс төрийн албан хаагч	7	7	7	7

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл /төгрөг/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,000,000	8,500,000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,000,000	8,500,000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,000,000	8,500,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,000,000	8,500,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,000,000	8,500,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,000,000	8,500,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000,000	8,500,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000,000	8,500,000

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Г.ГАНЧИМЭГ 2020.02.03

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2020.02.03

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.03

